

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/140/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

---

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт .....	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01178  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ  
СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН ДАРГА  
Г.ХАШЧУЛУУН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2021 01/ALBAN BICHIG  
19020541

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>43,444,818.56</u></b>	<b><u>143,261,985.88</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	74,039,200.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	74,039,200.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	74,039,200.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	43,444,818.56	69,222,785.88
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	22,156,503.82	27,798,112.75
35110	Тусгай зориулалттай материал	5,050,940.00	5,133,940.00
35130	Эм боох материал	17,105,563.82	22,664,172.75
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,288,314.74	41,424,673.13
35410	Бичиг хэргийн материал	742,800.00	564,300.00
35420	Аж ахуйн материал	19,179,015.74	40,569,110.63
35460	Хүнсний материал	1,366,499.00	291,262.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>561,036,027.25</u></b>	<b><u>525,347,258.53</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	561,036,027.25	525,347,258.53
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	552,682,027.25	517,023,258.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,197,006.00	460,197,006.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,168,763.76	-51,966,568.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,480,000.00	75,480,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,880,000.00	-54,780,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,491,517.75	133,109,967.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,922,712.19	-54,569,400.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,947,502.64	17,947,502.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,672,190.00	-9,344,915.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,050,000.00	2,050,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,500,833.19	-1,760,833.11
39217	Ном	660,500.00	660,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,354,000.00	8,324,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,354,000.00	8,354,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-30,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>604,480,845.81</u></b>	<b><u>668,609,244.41</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>25,887,742.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	25,887,742.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	25,887,742.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	7,546,172.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	18,341,570.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	18,341,570.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>604,480,845.81</u></b>	<b><u>642,721,502.41</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	604,480,845.81	642,721,502.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	220,397,712.25	220,397,712.25
51101	Өмч: - төрийн	220,397,712.25	220,397,712.25
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	218,484,142.04	256,724,798.64
51210	Өмнөх үеийн үр дүн	218,484,142.04	218,484,142.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	38,240,656.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,598,991.52	165,598,991.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>604,480,845.81</u></b>	<b><u>668,609,244.41</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>789,601,888.43</b>	<b>914,760,068.16</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>366,939,338.43</b>	<b>278,774,843.16</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	366,939,338.43	278,774,843.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	366,939,338.43	22,932,450.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	366,939,338.43	00.00
120005	Түрээсийн орлого		255,842,393.16
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>75,258,450.00</b>	<b>239,395,525.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	347,404,100.00	396,589,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,842,550.00	198,557,455.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,900,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,842,550.00	84,686,555.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		30,913,900.00
131106	Төсвийн урамшуулал		73,757,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	27,767,300.00	27,767,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,767,300.00	27,767,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	42,648,600.00	13,070,770.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42,648,600.00	13,070,770.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>479,164,740.66</b>	<b>876,519,411.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>479,164,740.66</b>	<b>876,519,411.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	477,878,880.27	872,908,150.38
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	288,010,100.00	303,290,635.59
210101	Үндсэн цалин	191,027,900.00	205,667,815.01
210102	Нэмэгдэл	76,093,600.00	59,534,628.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,200,000.00	4,751,192.10
210104	Урамшуулал	17,688,600.00	33,337,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,604,004.61	39,234,481.23
210201	Тэтгэврийн даатгал	27,080,604.61	29,995,468.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,883,100.00	2,320,305.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,304,100.00	1,856,224.53
210204	Ажилгүйдлийн даатгал	576,000.00	460,243.89
210205	Эрүүл мэндийн даатгал	5,760,200.00	4,602,238.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,606,049.00	27,450,872.00
210301	Гэрэл, цахилгаан	3,625,049.00	4,735,472.00
210302	Түлш, халаалт	21,600,000.00	22,334,400.00
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,595,166.49	33,187,728.67
210401	Бичиг хэрэг	2,291,600.00	2,178,500.00

**Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	18,150,000.00	25,490,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,949,988.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,153,566.49	68,450.67
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>43,215,373.72</b>	<b>254,406,168.74</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,321,202.72	243,195,965.24
210502	Хоол, хүнс	7,918,791.00	10,260,403.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,975,380.00	949,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,446,960.00</b>	<b>21,353,207.17</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,103,500.00	5,843,589.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	405,760.00	14,359,618.17
210604	Урсгал засвар	937,700.00	1,150,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>932,000.00</b>	<b>460,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	932,000.00	460,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>345,200.00</b>	<b>00.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,124,026.45</b>	<b>193,525,056.98</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,451,540.00	134,903,838.26
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,672,486.45	58,621,218.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,285,860.39</b>	<b>3,611,261.18</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>1,008,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,285,860.39</b>	<b>2,603,261.18</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,285,860.39	2,603,261.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>310,437,147.77</u></b>	<b><u>38,240,656.60</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>18,760,078.85</b>	<b>00.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	18,181,440.28	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-18,760,078.85</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>291,677,068.92</u></b>	<b><u>38,240,656.60</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	220,397,712.25	172,653,598.99	-96,292,534.35	296,758,776.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>172,653,598.99</b>	<b>-96,292,534.35</b>	296,758,776.89
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,102,658.15	-11,102,658.15
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>165,598,991.52</b>	<b>218,484,142.04</b>	<b>604,480,845.81</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>165,598,991.52</b>	<b>218,484,142.04</b>	<b>604,480,845.81</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>165,598,991.52</b>	<b>218,484,142.04</b>	<b>604,480,845.81</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	38,240,656.60	38,240,656.60
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>220,397,712.25</b>	<b>165,598,991.52</b>	<b>256,724,798.64</b>	<b>642,721,502.41</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>422,662,550.00</b>	<b>562,228,225.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>422,662,550.00</b>	<b>562,228,225.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	347,404,100.00	396,589,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,842,550.00</b>	<b>124,800,455.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	5,900,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,842,550.00	84,686,555.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	30,913,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>27,767,300.00</b>	<b>27,767,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,767,300.00	27,767,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,648,600.00</b>	<b>13,070,770.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42,648,600.00	13,070,770.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>421,920,450.00</b>	<b>562,228,225.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>421,920,450.00</b>	<b>562,228,225.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>420,634,589.61</b>	<b>558,616,963.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>288,010,100.00</b>	<b>303,291,435.59</b>
210101	Үндсэн цалин	191,027,900.00	205,667,815.01
210102	Нэмэгдэл	76,093,600.00	59,534,628.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,200,000.00	4,751,192.10
210104	Урамшуулал	17,688,600.00	33,337,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,604,004.61</b>	<b>39,233,681.23</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,083,604.61	29,994,668.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,880,100.00	2,320,305.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,304,100.00	1,856,224.53
210204	Ажилгүйдлийн даатгал	576,000.00	460,243.89
210205	Эрүүл мэндийн даатгал	5,760,200.00	4,602,238.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,606,049.00</b>	<b>26,617,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,625,049.00	4,636,300.00
210302	Түлш, халаалт	21,600,000.00	21,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,150,000.00</b>	<b>24,235,000.00</b>
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,150,000.00	17,235,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,500,000.00

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	20,409,636.00	27,037,092.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,409,636.00	18,037,092.00
210502	Хоол, хүнс	9,000,000.00	9,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,272,400.00	8,481,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,690,900.00	3,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,431,500.00	4,131,500.00
210604	Урсгал засвар	1,150,000.00	1,150,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	932,000.00	460,000.00
210702	Дотоод албан томилолт	932,000.00	460,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,574,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,076,400.00	129,260,955.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,076,400.00	129,260,955.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,285,860.39</b>	<b>3,611,261.18</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,008,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,285,860.39	2,603,261.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,285,860.39	2,603,261.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>742,100.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>742,100.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>742,100.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	742,100.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	742,100.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-742,100.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	466,763,000.00	434,824,508.82	31,938,491.18	93.16
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	466,763,000.00	434,824,508.82	31,938,491.18	93.16
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	466,763,000.00	434,824,508.82	31,938,491.18	93.16
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	328,565,300.00	303,291,435.59	25,273,864.41	92.31
210101	Үндсэн цалин	222,251,900.00	205,667,815.01	16,584,084.99	92.54
210102	Нэмэгдэл	66,675,600.00	59,534,628.48	7,140,971.52	89.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	4,751,192.10	1,548,807.90	75.42
210104	Урамшуулал	33,337,800.00	33,337,800.00	00.00	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,356,200.00	39,233,681.23	5,122,518.77	88.45
210201	Тэтгэврийн даатгал	31,213,400.00	29,994,668.59	1,218,731.41	96.10
210202	Тэтгэмжийн даатгал	3,285,700.00	2,320,305.68	965,394.32	70.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,628,500.00	1,856,224.53	772,275.47	70.62
210204	Ажилгүйдлийн даатгал	657,200.00	460,243.89	196,956.11	70.03
210205	Эрүүл мэндийн даатгал	6,571,400.00	4,602,238.54	1,969,161.46	70.03
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,617,300.00	26,617,300.00	00.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,636,300.00	4,636,300.00	00.00	100.00
210302	Түлш, халаалт	21,600,000.00	21,600,000.00	00.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00	00.00	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,935,000.00	20,935,000.00	00.00	100.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,935,000.00	13,935,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,500,000.00	00.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	27,039,200.00	27,037,092.00	2,108.00	99.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,039,200.00	18,037,092.00	2,108.00	99.99
210502	Хоол, хүнс	9,000,000.00	9,000,000.00	00.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,481,500.00	8,481,500.00	00.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,200,000.00	3,200,000.00	00.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,131,500.00	4,131,500.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	1,150,000.00	1,150,000.00	00.00	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,000,000.00	460,000.00	1,540,000.00	23.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	460,000.00	1,540,000.00	23.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8768500.00	8768500.00	00.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,768,500.00	8,768,500.00	00.00	100.00

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	466,763,000.00	437,427,770.00	29,335,230.00	93.72
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	396,589,700.00	396,589,700.00	00.00	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	396,589,700.00	396,589,700.00	00.00	100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	27,767,300.00	27,767,300.00	00.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	27,767,300.00	27,767,300.00	00.00	100.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	42,406,000.00	13,070,770.00	29,335,230.00	30.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42,406,000.00	13,070,770.00	29,335,230.00	30.82

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>124,800,455.00</b>	<b>124,800,455.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>124,800,455.00</b>	<b>124,800,455.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	123,792,455.00	123,792,455.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,300,000.00	3,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	3,300,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	120,492,455.00	120,492,455.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,492,455.00	120,492,455.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,008,000.00	1,008,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,008,000.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	1,008,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	124,800,455.00	124,800,455.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	124,800,455.00	124,800,455.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,900,000.00	5,900,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	3,300,000.00	3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,686,555.00	84,686,555.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,913,900.00	30,913,900.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө, бараа материалыг үнэн зөв ангилан бүртгэх, анхан шатны баримтад үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв бэлтгэж тайлагнах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэхийг эрхэм зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн даргын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, дотоод хяналтын ажлын тайланг улирал бүр тайлагнасан.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны ажлын төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 466,763.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,001.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,251.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 466,763.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 437,427.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 93.7 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 124,800.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 562,228.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд 22,932.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 22,932.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 22,932.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 255,179.9 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 179,232.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 408,634.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

**Авлага, өглөгийн талаар:**

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 74,039.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, 25,887.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь ЭМДЕГ-аас авах санхүүжилтийн авлага, эм боох материалын өглөг байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн данс болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансанд үлдэгдэлгүй байна. Бараа материал 69,222.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 525,347.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	74,039.2	74,039.2
Урьдчилгаа			-
Бараа материал	43,444.8	69,222.8	25,778.0
Үндсэн хөрөнгө	561,036.0	525,347.3	(35,688.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>604,480.8</b>	<b>668,609.2</b>	<b>64,128.4</b>
Өр төлбөр	-	25,887.7	25,887.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	604,480.8	642,721.5	38,240.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>604,480.8</b>	<b>668,609.2</b>	<b>64,128.4</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 69,222.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 25,778.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 525,347.3 мянган төгрөг болж 35,688.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 642,721.5 мянган төгрөг болж 38,240.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 835,889.5 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 835,889.5 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 369,126.5 мянган төгрөгөөр бууруулж, 466,763.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 396,589.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 27,767.3 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 13,070.8 мянган төгрөгийн, нийт 434,824.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 434,824.5 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 2,603.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 434,824.5 мянган төгрөг буюу 93.2 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 124,800.5 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 123,792.5 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 1,008.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 25,778.0 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 өвчний үед шаардлагатай эм бэлдмэл, хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодисын бэлэн байдлыг хангах зорилгоор бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Тайлант хугацааны худалдан авалтыг и-баримттай тулгахад харилцагч байгууллагатай хийсэн 33,179.2 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүйг завсрын аудитаар илрүүлж, жилийн эцсээр зөрчлийг арилган ажилласан. Баянчандмань сумын Эргэлтийн эмийн сан нь 22,685.6 мянган төгрөгийн эмийн борлуулалтын орлогыг и-баримтаар баталгаажуулаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон Коронавируст халдвар /Ковид-19/ -ын тусламж үйлчилгээний санхүүжилтийг хувийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай эм, эмийн нөөц бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт, өвчтөний хоол, улаан бүсэд ажилласан эмч, ажилчдын цалин зэрэгт бүрэн зарцуулж, уг үйл ажиллагааг санхүүгийн тайланд толилуулсан.

## **3.8 Аудитын гол асуудал**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 19 нэр төрлийн 54,352.2 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалын дансанд 14 нэр төрлийн 3,247.7 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус тус бүртгэлтэй, тайлант онд 3 албан хаагчийн цалингийн цэсээр бодогдсон цалинг 493.8 мянган төгрөгөөр НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 174 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 25,008.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 64,841.6 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 1 алдааг залруулж, зөрчил арилгах 6,747.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 58,093.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 1 алдааг залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулгахад санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант оны үр дүн зөрүүтэй тайлагнасан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

##### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тусгасан 282.2 мянган төгрөгийн авлага, 6,465.7 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. ЭМТ-ийн даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/68 дугаар "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" тушаалаар тооллогын ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэсэн боловч тооллогын үр дүнг хэлэлцээгүй, баталгаажуулаагүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж, тооллогын үр дүнг баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 19 нэр төрлийн 54,352.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

**2. Бараа материалын данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд 14 нэр төрлийн 3,247.7 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоолын 1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторхи зүйлийг НББОУС-д нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэхийг дарга, захирал нарт даалгасугай" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгө, бараа материалын дансыг зөв ангилан бүртгэх

**3. Зардлын данстай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Тайлант онд 3 албан хаагчийн цалингийн цэсээр бодогдсон цалинг 493.8 мянган төгрөгөөр НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтад үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв тайлагнаж байх

**4. Шилэн данстай холбоотой асуудал**

**4.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд оруулбал зохих 176 мэдээллээс хугацаандаа оруулсан 174 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**4.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэт мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлэг	7	64,841.6	1	-	-	-	2	6,747.9	4	58,093.7

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)